

Ажлын хуудас №2

Даалгавар №1 \Өмнөх мэдлэгээ сэргээн сануулах\



Зургийг ажиглаарай:

Монгол улсад хоногийн аль үе болж байна вэ?

А. Зүүдний ертөнцөөр тавтай аялаарай.


Б. Үүр цайж, удахгүй нар мандах нь ээ...

В. Ямар сайхан өглөө вэ?

Г. Бага үд болж байна. Удахгүй болох завсарлагаанаар найзтайгаа уулзана.

Д. Өнөөдөр хичээл дээр сонирхолтой байлаа.

Асуултын хариулт:



Даалгавар №2 \Ойлгосон эсэхийг шалгах\

Өдөр шөнө ээлжилж байгаа үзэгдлийг бичлэгээр харуулж асуулт дэвшүүлэх. Хэрвээ дэлхий тэнхлэгээ эргэдэггүй байсан бол? \Сурагчид өөрсдийн таамаглалаа дэвшүүлэх\



Сурагчдын өгч болох хариултууд:

- Хэрвээ дэлхий тэнхлэгээ эргэдэггүй байсан бол дэлхийн нар тусч байгаа хэсэгт үргэлж өдөр байна. Харин эсрэг талд нь үргэлж шөнө байна.
- Дэлхийн нэг тал нь байнга өдөр болж, нөгөө талд нь байнга шөнө болдог.
- Өдөр шөнө ээлжлэх боломжгүй болно.

Даалгавар №3 Нар гарахаар өдөр, сар гарахаар шөнө болдог уу? Заримдаа өдөр ч сар гарсан байдаг, зарим шөнө сар харагддаггүй шүү дээ! Зурагнуудыг сайн ажиглаарай.



Асуулт 1. Доорх зурагт өгөгдсөн сар ямар сар вэ? Сар аль талаасаа гэрэлтэж байна вэ?



Ямар сар вэ?

Аль талаасаа гэрэлтэж байгаа вэ?

.....

Хариулт: Тал сар байна. Сар зүүн гар талаасаа гэрэлтэж байна. Тэнгэрийг ажиглах юм бол энэ шөнө биш байна.

Асуулт 2. Хүүхдүүдээ, тэгвэл сар хөдөлдөг юм болов уу?

Билгүүн:

Шөнө болоогүй ч гэсэн сар харагддаг байх нь ээ...

Болд:

Хичээлдээ ирэхэд харагдаж байсан сар хичээлийн харагдахгүй болсон.

Жаргалын таамаглал:

Сар хөдөлж байгаа учраас харагдахгүй болсон байх.

Чиний таамаглал:


.....
.....
.....

Туршилт: Та нарт нэгэн туршилтын үр дүнг танилцуулъя.


- Сарын харагдах байдлыг 30 минутын зайтай 3 удаа ажигласан байна.
- Ажиглалтыг хийхдээ сарыг хөдөлгөөнгүй зүйлтэй \шонтой\ харьцуулж ажигласан байна.
- Сарны аль зүгт байгааг тодорхойлохын тулд луужин ашигласан байна.

Ажиглалт хийсэн сар өдөр	2020.05.14
Ажиглалт – 1	Өглөөний 07:00 цагт
Ажиглалт – 2	Өглөөний 07:30 цагт
Ажиглалт – 3	Өглөөний 08:00 цагт

Туршилтын үр дүнг харуулсан зурагнуудыг сайн ажиглаарай.



Ажигласан зүйлээ дараах хэсэгт зурцгаая:



Ажиглалтын үр дүнгээс олж харсан зүйлээ бичнэ үү.

.....

.....

.....

.....

.....

.....

1. Сарны байрлал яагаад өөрчлөгдсөн бэ?

- Дэлхий тэнхлэгээ эргэдэгтэй холбоотой.
- Сар дэлхийг тойрдогтой холбоотой.
- Дэлхий нарыг тойрдогтой холбоотой.
- Сар нарыг тойрдогтой холбоотой.

Сар дэлхийг ойролцоогоор хэдэн хоногт 1 бүтэн тойрдог вэ?

- 27 хоног
- 27.3 хоног
- 28 хоног
- 30 хоног

Гэртээ очоод хийх даалгавар \туршилт\:

Сарыг ажиглах төлөвлөгөө:

Хэзээ?	Сар харагдах цэлмэг өдөр
Хаана?	Сарыг ажиглах газар сонгох
Хэрхэн?	30 минутын зайтай 3 удаа ажиглах



Анхааруулга: Туршилтыг нэг л газарт зогсож хийнэ. Хэрвээ өөр өөр газраас сарыг ажиглах юм бол туршилтын үр дүн алдаатай гарна. Сарыг ажиглахдаа нэгэн үл хөдөлдөг зүйлийн сонгож аваарай \мод, шон, эсвэл гэрийн дээвэр, ...г.м\.

Туршилтын тэмдэглэлийн хуудас:

Сурагчийн нэр:

Ажиглалт хийсэн сар, өдөр:

Ажиглалтын үр дүнг зурах хэсэг:




Ажиглалт хийсэн цаг:

Ажиглалт 1: цаг мин


Ажиглалт 2: цаг мин

Ажиглалт 3: цаг мин


Ажиглалтын үр дүнгээс олж
харсан зүйлээ бичнэ үү.



201.. оны ... сарын-
ны ... цаг орчим



201.. оны ... сарын-
ны ... цаг орчим



201.. оны ... сарын-
ны ... цаг орчим